

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-6

1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай/	4-6
---	-----

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит
Чуулганы Инновац, цахим бодлогын байнгын хорооны
06 дугаар сарын 10-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Ж.Золжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 63.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 55 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Галбадрах;
Тасалсан: Б.Пунсалмаа.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Инновац, цахим бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ байлцав.

Байнгын хорооны дарга Ж.Золжаргал тогтоолын төслийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Ж.Золжаргал хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс санал гараагүй болно.

Ж.Золжаргал: “Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	7
Татгалзсан	2
Бүгд	9

77.8 хувиар санал Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 08 минут үргэлжилж, 11 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 81.8 хувийн ирцтэйгээр 15 цаг 03 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.ЗОЛЖАРГАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ГЭРЭЭТ АЖИЛТАН

Д.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Их засаг” танхимд 14 цаг 55 минут

**ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ж.Золжаргал: Инновац, цахим бодлогын байнгын хорооны эрхэм гишүүддээ өдрийн мэнд хүргэе ээ. Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн 72.7 хувьтай ирц бүрдсэн тул 2025 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Ингээд хэлэлцэх асуудал танилцуулъя. Эхлээд ирцээ танилцуулах ёстой. Ирцээ танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, Э.Батшугар, А.Ганбаатар, Ж.Золжаргал, Ц.Мөнхбат, Т.Мөнхсайхан, Ч.Ундрэм, С.Цэнгүүн нар хуралдаа оролцож ирцэндээ орсон байна аа.

Хэлэлцэх асуудлыг та бүхэндээ танилцуулъя.

Нэг.Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл. Энэ тогтоолын төсөл маань түрүүчийн Байнгын хороон дээр бид хэлэлцээд ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэг маань бол Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хэрэгжилт хангалтгүй байгаа учраас хуулийн хэрэгжилтийг дүн шинжилгээ хийгээд тэгээд дагалдах хуулиуд дээр нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулах шаардлагатай бол ийм зорилготой байгаа.

Тэгэхээр энэ ажлын хэсгийн удирдамжийн төслийг боловсруулаад гишүүдэд та бүхэнд тараасан байгаа. Тэгээд энэ талаар одоо энэ удирдамж батлах ийм асуудал байна аа. Улсын Их Хурлын гишүүн Номин орж ирсэн байна аа.

Ингээд хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүн байна уу? Байхгүй байна аа. Тэгээд хэлэлцэх асуудалтай холбоотой санал байхгүй. Асуулт. Та микрофон аваад ярих уу. Батшугар гишүүний микрофон нээж өгье.

Э.Батшугар: Эрхэм Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ тогтоолын төсөл дээр 7 дугаар хэсэгт нь ажлын хэсгийн үйл ажиллагааны хуваарь дээр 25 оны 12 сард хуулийн төслийн хэлэлцүүлэгт оруулах бэлтгэл хангах гэж байна. Энэ ямар хуулийн төсөл шинээр бэлтгэж оруулах юм. Бид нар чинь хуулиа батлаад жил ч болоогүй байгаа. Тэгэхэд илүү одоо хуулийн хэрэгжилт дээр нь анхаарах ёстой юм биш үү. Маш олон журмаа Засгийн газраас батлах ёстой байгаад байдаг гэх мэтчилэн зүйлүүд байна аа.

Ж.Золжаргал: Ажлын хэсгийн маань зорилго нь Мэдээллийн технологи үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн бодит байдалд дүн

шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг тодорхойлох шаардлагатай бол хуульд өөрчлөлт оруулах төслийг боловсруулах үүрэг бүхий гэж байгаа.

Тэгээд энэ удирдамж дээр буулгасан байгаагаар бол хуулийн төслийг боловсруулахдаа холбогдох хууль тогтоомжтой нь нийцүүлэх, шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах саналуудыг нэгтгэн боловсруулна аа. Үүнд дараах хууль тогтоомж багтана аа.

Нэгд, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль;
Хоёр. Мөнгө угаах болон терроризмын санхүүжилтийг дэмжих тухай хууль;
Гурав. Харилцаа холбооны тухай хууль;
Дөрөв. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль;
Тав. Хөрөнгийн үнэлгээний тухай хууль;
Зургаа. Бусад холбогдох хууль тогтоомж гээд.

4.2-т нь болохоор хуулийн дагалдах журам боловсруулах. Энэ журмууд нь боловсруулагдаж байгаа журмууд мэдээллийн технологи үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн ажиллах журам гэж батлагдсан байх аа. Батлагдсан.

Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд үзүүлэх татварын болон татварын бус дэмжлэгийн журам, хиймэл оюун ухаан, их өгөгдөл, блокчэйн, сансрын үйлдвэрлэлийн дэвшилтэт технологид суурилсан сөнд боксын зохицуулалт бусад шаардлагатай дүрэм журам гээд.

Ингээд энэ хуулийн хэрэгжилттэй холбоотой Цахим хөгжил, инновац харилцаа холбооны сайдаас мэдээлэл авсан. Мэдээлэл аваад ерөнхий дүгнэлт бол журмуудын зарим нь боловсруулагдаж байгаа, зарим нэг нь батлагдсан, зарим нь бол ялангуяа санхүү, нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой, татвар, нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой урамшууллууд холбогдох хуулиуд дээр өөрчлөлт орохгүй бол журмаар зохицуулах боломжгүй байна аа гэсэн дүгнэлт танилцуулсан.

Тэгээд тэрийг жишээ болгоод одоо энэ 6 ийм хуулийн нэмэлт өөрчлөлтийг хийх хэрэгтэй юм байна аа гэж 4 сард яамнаас бол мэдээлэл өгсөн байгаа. За тэгээд энэ биш ээ 3 дугаар сард тэгээд 4 дүгээр сард бид нар энэ нэмэлт өөрчлөлтүүдийн төслийн талаар мэдээлэл өгөөч ээ гэсэн өгч амжсангүй.

Тийм болохоор ингээд Байнгын хороон дээр ажлын хэсэг гаргаад энэ боломжуудыг нь бүгдээрэнгий нь нягталж үзээд, тэгээд шаардлагатай бол нэмэлт, өөрчлөлтүүдийн төсөл боловсруулъя гэсэн ийм агуулгатай байна.

Ингээд асуулт асуусан. Тогтоолын төсөлтэй холбоотой үг хэлэх гишүүн. Үг хэлэх гишүүн байхгүй байна.

Тэгвэл тогтоолын төслийг уншиж танилцуулаад санал хураалт явуулъя.

Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалтыг үндэслэн Инновац, цахим бодлогын байнгын хорооноос Тогтоох нь:

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл бэрхшээл, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг тодорхойлох, шаардлагатай бол хуульд өөрчлөлт оруулах төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамжийг хавсралтаар баталсугай.

2.Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамжид хяналт тавьж ажиллахыг ажлын хэсэг Ж.Золжаргалд даалгасугай.

Тогтоолын төслийг дэмжье. Гишүүд санал хураалтад бэлдье. Санал хураахад бэлэн боллоо.

Уншиж танилцуулсан тогтоолын төслийг дэмжье гэдэг томъёоллоор санал хураалт.

77.8 хувиар санал дэмжигдлээ.

Түрүүчийн парламент Байнгын хорооны үеэр боловсруулж батлагдсан чухал хуулийг эрчимжүүлэх, хэрэгжилтийг сайжруулахад энэ удаагийн парламент Байнгын хорооноос анхаарч ажиллах нь бас төрийн бодлогын залгамж халаа юмаа гэж бодож байна. За дэмжсэнд баярлалаа.

Ингээд хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ГЭРЭЭТ АЖИЛТАН

Д.ЭНЭБИШ